

## ӨМНӨД ХӨРШИЙН ХӨГЖИЛ БА МОНГОЛ УЛС

Д.ШҮРХҮҮ \*

Хөршөө, түүний дотор хөрш орноо сонгодоггүй гэдэг билээ. Монгол орон дэлхийн хамгийн том нутаг дэвсгэртэй (17 сая км<sup>2</sup>) ОХУ, хамгийн их хүн амтай (1.3 тэрбум) БНХАУ хэмээх хоёр хүчирхэг гүрний завсарт нэн өвөрмөц нөхцөл дунд оршин тогтнодог. ХХ зууны турш монголчууд энэ хоёр хөрштэйгээ хэрхэн харилцах, хөрш орны хүчин зүйл Монгол орны хувь заяанд хэрхэн нөлөөлдөг талаар багагүй туршлага хуримтлууллаа. Гол сургамж бол аль нэг хөрштэйгээ хэтэрхий дайсагнах, мөн улс төр, эдийн засгийн хувьд хэтэрхий хараат байхын уршиг дагаврыг сайтар мэдэрсэн явдал юм. Мөн хөршүүдийн, ялангуяа Хятадын тогтвортой байдал, эдийн засгийн эрчимтэй хөгжлийн хаялга Монголд хэрхэн эерэгээр нөлөөлсөнийг өнгөрсөн 20 жилийн практик харууллаа. Гэхдээ сүүлийн жилүүдэд хоёр хөршийн эрчимтэй хөгжлийн сүүдэр ч манайд тусах болсоныг тэмдэглэх хэрэгтэй.

Бидний өмнө түүхэн ховорхон боломж бололцоо, шинэ сорилт, бэрхшээлүүд хосолсон амаргүй хувь тавилан хүлээж байна. Жилээс жилд хүчирхэгжиж буй Орос, Хятад жижиг Монголд хэрхэн нөлөөлөх вэ гэдэг асуудал үүний гол цөм байх болно. Энэ өгүүлэлд өмнөд хөршийн үсрэнгүй хөгжил, хүч чадлын өсөлт Монгол Улсад үзүүлэх нөлөөллийг гол төлөв эдийн засаг, зах зээл, сүүлийн үед олон улсын харилцаа судлалд түгээмэл хэрэглэх болсон софт хүчин чадлын онолын үүднээс судлан үзүүлэхийг хичээлээ.

### Дэлхий Хятадаас улам бүр хамааралтай болж байна

Хятадын “эдийн засгийн гайхамшиг” бараг дэлхийн хүн бүрийг гайхашруулж, тус орны өнөө ба хэтийн төлвийн асуудал олон судлаачдын сонирхон судлах, хүчээ үзэх хамгийн “моодны” сэдэв хэвээр байна.

БНХАУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ 2003-2006 онуудад дунджаар 10.4% өссөн бол дэлхийн дундаж 4.9% байв. Олон улсын валютын сангийн мэдээлснээр 2006 онд Хятад улс эдийн засгийн өсөлтийн хурдаар дэлхийн 180 орны дотор 11-р байранд орсон байна. Мөн оны байдлаар Хятадын эдийн засгийн цар хэмжээ 2 645.0 тэрбум ам.долларт хүрснээр дэлхийн ДНБ-ний 5.5% бүрдүүлдэг 4 дэх том эдийн засаг болжээ. Харин 2002 онд Хятад улс 6-рт жагсаж, дэлхийн эдийн засгийн 4.4% эзэлж байлаа<sup>1</sup>. 2007 онд Хятадын эдийн засгийн өсөлт 11% -иас давах төлөвтэй байна.<sup>2</sup>

Хятадын Статистикийн газрын мэдээгээр 2006 онд тус орон мах (80.5 сая тн.), үр тариа (497.5 сая тн.), хөвөн (6.7 сая тн.), нүүрс (2.3 тэрбум тн.), цемент (1.2 тэрбум тн.), химийн бордоо (53.4 сая тн.) үйлдвэрлэлтээр дэлхийд тэргүүлдэг бол ган (419 сая тн.), цахилгаан эрчим хүч (2865.7 тэрбум квт/ц) үйлдвэрлэлээр 2-рт, түүхий нефть (184.7 сая тн.) олборлолтоор 5-рт ордог байна.<sup>3</sup>

Гадаад худалдааны нийт эргэлт 2006 онд 1 760.4 тэрбум ам.долл-т хүрч дэлхийд эхний гуравт орох болсон бөгөөд 2002 оныхоос 3 дахин нэмэгджээ. Экспорт 968.9 тэрбум, импорт 791.4 тэрбум, худалдааны баланс 177.5 тэрбумын ашигтай гарчээ.<sup>4</sup>

\* Д.Шүрхүү. ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

<sup>1</sup> Китай- четвертая по объему экономики страна в мире. 12/10/2007. Синьхуа агентлагийн мэдээ

<sup>2</sup> Жэньминь жибао он-лайн, 2007.11.27

<sup>3</sup> Хятадын статистикийн 2007 оны лавлах / 中国统计年鉴-2007 /

<sup>4</sup> Мөн тэнд, 18-3 Total Value of Imports and Exports,

БНХАУ-ын гадаад валютын нөөц 2006 оны эцсээр 1 триллион ам долларын босгыг давж, сүүлийн жилүүдэд дэлхийд тэргүүлж байсан Японыг /909 тэрбум ам долл./ гүйцэв.<sup>5</sup> 2007 оны 10-р сарын эхэнд уг нөөцийн хэмжээ 1.43 триллион ам долларт хүрчээ.<sup>6</sup>

Хятад улс хөгжиж буй орнуудын дотор хамгийн их гадаадын хөрөнгө татдаг орон юм. 2006 онд Хятадад оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын /ГШХО/ хэмжээ 5% өсч, 63 тэрбум ам.долларт хүрлээ гэж БНХАУ-ын Худалдааны сайд Бо Силай мэдэгджээ. 2004 онд ГШХО-ын хэмжээ 72.4 тэрбум ам.доллар байсан бол 2005 оноос энэ үзүүлэлт мэдэгдэхвйц буурсан юм.

Мөн Хятадаас гадаад орнуудад оруулж буй хөрөнгө оруулалт ч ихээхэн өсч байна. 2006 оны эцэст Хятадын 5000 хуулийн этгээд дэлхийн 172 оронд 1 түм гаруй компанид нийт 90.6 тэрбум ам.долл-ын хөрөнгө оруулсаны дотор зөвхөн 2006 онд 21.2 тэрбум ам долларын хөрөнгө оруулалт хийж, дэлхийд 13-р байранд орох болжээ.<sup>7</sup>

Шинжлэх ухаан, технологи болон батлан хамгаалах салбараа хөгжүүлэхэд ч Хятад улс ихээхэн анхаарч багагүй төсөв хөрөнгө зарцуулж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын /ОЕСД/ гаргасан судалгаагаар Хятад улс 1995 оноос хойш шинжлэх ухаанд зарцуулах төсвөө жил бүр 19% нэмэгдүүлж ирсний дүнд 2005 оны байдлаар 30 тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэ нь дэлхийд 6-рт орох, ДНБ-тэй харьцуулсан хувийн жинг 2 дахин өсгөж 1.34% хүргэх боломжийг бүрдүүлсэн байна.<sup>8</sup> Үүний үр дүнд шинжлэх ухаан, технологийн дэвшил олон чиглэлээр ахиц дэвшилд хүрсний дотор сансарын уудмыг шинжлэн судлах салбар багтаж байна. БНХАУ 2005 оны 10-р сард 2 хүнтэй сансарын хөлгийг хөөргөж сансарт жолоодлогот нислэг бие даан хийсэн дэлхийн гуравдахь орон болсон

төдийгүй 2007 онд сар луу анхны “Чан Ө-1” хиймэл дагуул илгээж, ирэх онд 3 хүнтэй баг сансар руу явуулах, улмаар гариг хоорондын нислэг хийх асар том хөтөлбөр бэлтгэж байна.<sup>9</sup>

Олон улсын валютын сангийн тооцоогоор 1996-2006 онуудад БНХАУ-ын батлан хамгаалах зардал жилд дунджаар 11.8%, Хятадын талын эх сурвалжаар /Батлан хамгаалахын цагаан ном, 2006/ 1990-2005 онуудад 9.6 % өсч ирсэн мэдээ байна.<sup>10</sup> 2007 оны төсөв урьд оныхоос 17.8% өсч 350 тэрбум юань буюу \$45 тэрбумд хүрсэн ажээ.<sup>11</sup>

Олон орны хятад судлаачдын нийтлэг хүлээн зөвшөөрдөг зүйл бол 30 шахам жил үргэлжилж буй Хятадын шинэтгэлийн гол үр дүн бол Хятадын эдийн засаг дэлхийн эдийн засгийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон төдийгүй түүний нэг чухал хөдөлгөгч хүч болж буй явдал юм. Дээр дурдсан тоо баримт ч Хятад улс дэлхийн томоохон үйлдвэрлэгч, нийлүүлэгч, мөн хэрэглэгч болсоныг тодорхой харуулж байна.

Өрнөдийн, ялангуяа АНУ-ын бодлого боловсруулагчид, судлаачдын хамгийн их сэтгэл зовоож буй асуудал бол өмнөд хөршийн зах зээл, эдийн засгийн тогтвортой хөгжил юм. Асуудлын мөн чанар Хятад улс дэлхийн засагт эзлэх байр суурь, нөлөө өдрөөс өдөрт өсч буйд оршино. Дэлхийн банкны ерөнхийлөгч Роберт Зеллик саяхан Хятадад айлчлах үеэрээ “Хятад улс дэлхийн эдийн засагтай нягт харилцан уялдаатай болж буйг онцлон тэмдэглээд, дэлхийн тогтвортой байдлыг хангахад БНХАУ улам их хариуцлага хүлээж байгааг сануулсан юм. Тэрбээр “China Daily” сонинд өгсөн ярилцлагандаа дэлхийн эдийн засгийн өсөлтийн хурдац удаашрахын эсрэг тэмцэлд Хятад улс манлайлах үүрэг гүйцэтгэх боломжтойг дурдаад, шинэ шинэ асуудлыг шийдвэрлэхийн тулд бусад оронтой эдийн

<sup>5</sup> МОНЦАМЭ-гийн мэдээ, 2007/04/13

<sup>6</sup> China's forex reserve tops \$1.43 trillion, October 12, 2007, <http://news.xinhuanet.com>

<sup>7</sup> С агентлагийн мэдээ, 17/09/2007

<sup>8</sup> Innovation: Research and development is slow to grow, By Mure Dickie, The Financial Times, October 9, 2007

<sup>9</sup> First Chinese-built satellite heralds growing space program, May 15, 2007 The Washington Post; Ожидает ли мир новая космическая гонка?, Наа 31.10.2007,

<sup>10</sup> ANNUAL REPORT TO CONGRESS Military Power of the People's Republic of China, Secretary of Defense, USA

<sup>11</sup> Beijing increases defense spending, By David Lague Sunday, International Herald Tribune, March 4, 2007

засгийн бодлогоо уялдуулан зохицуулахыг Хятадын эрх баригчдад уриалжээ. Роберт Зеллик Дэлхийн банкны ерөнхийлөгчөөр сонгогдох хвртлээ АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын нэгдүгээр орлогчийн албан тушаал хашиж байхдаа Хятадтай оновчтой яриа хэлцээ хийж, “хариуцлагатай” гүрний хувиар дэлхий нийтийн шинжтэй асуудлуудыг шийдвэрлэхэд тус орныг татан оролцуулахыг эрмэлзэж байсан юм.<sup>12</sup>

### Монгол Улсын хөгжилд үзүүлэх Хятадын эдийн засгийн нөлөө

Юуны өмнө Монгол Улсын эдийн засаг, худалдааны хөгжил, зах зээлийн тэлэлтэд Хятадын зүгээс үзүүлэх эерэг хүчин зүйлсийн нөлөө, ач холбогдол жилээс жилд нэмэгдэж байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Хэрэв дэлхийн хамгийн эрчимтэй хөгжиж буй том эдийн засаг, өдрөөс өдөрт эрэлт хэрэгцээ нь өсөн нэмэгдэж байгаа хамгийн том зах зээл манай улстай хаяа дэрлэн оршиж байгаагүй бол манай улсын эдийн засгийн өсөлтийн хурд харьцангуй доогуур байх магадлал өндөр юм. Монгол Улсын цогц хөгжлийн үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд өмнөд хөршийн хөгжлийн эрч далайц, зах зээлийг хэрхэн үр өгөөжтэй ашиглаж, мөн тэндээс ирэх дарамт, өрсөлдөөн, аюул, сөрөг нөлөөллийг хэрхэн амжилттай даван туулах явдал улс төр, эдийн засгийн төдийгүй онол-практикийн нэн чухал ач холбогдолтой асуудал юм.

Хоёр орны худалдааны эргэлтийг аваад үзэхэд Хятадын зах зээлийн гүйцэтгэж буй үүрэг тодорхой харагдаж байна. Тухайлбал, 2006 онд Монгол Улсын гадаад худалдааны нийт хэмжээ 2005 оныхоос 800 сая ам доллараар нэмэгдэж 3 тэрбум ам долл. давсаны дотор Хятад улстай хийсэн худалдааны хэмжээ 644 саяар нэмэгдэж, нийт эргэлтийн 1.5 тэрбум буюу тэн хагасыг эзлэх болжээ. Эндээс харахад манай улсын гадаад худалдааны нийт эргэлтийн өсөлтийн 80 хувийг Хятадын зах зээл бүрдүүлсэн байна.<sup>13</sup>

Монголын экспортын зах зээлийн 70 орчим хувийг Хятад улс дангаараа

бүрдүүлдэг бөгөөд 2005 онд 48.3 % эзэлж байв. Монголын экспортын өсөлтөд Хятадын оруулж буй хувь хэмжээ ч их өндөр байна. 2005 онд Монгол Улсаас Хятад руу 514 сая ам долл-ын бараа бүтээгдэхүүн гаргаж байсан бол 2006 онд уг хэмжээ 1 дахин нэмэгдэж 1050.0 сая ам долларт хүрчээ. Харин Монгол Улсын экспортын нийт хэмжээ 1064.9 сая ам.доллараас 1542.8 сая ам.долларт хүрч 478 сая доллараар нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын нийт экспортын өсөлтөөс Хятадын руу гаргасан экспортын өсөлт давсан гэсэн үг юм<sup>14</sup>. Энд хэдийгээр Монголын экспортын гол бүтээгдэхүүн болох зэс, цайрын баяжмалын дэлхийн зах зээлийн үнэ өссөн байдал нөлөөлж буй боловч ерөнхийдөө хоёр орны худалдааны динамик өсөлтийг илтгэн харуулж байна.

Хятад улсын эдийн засгийн түргэн хөгжлийг даган тус орны эрдэс түүхий эдийн эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэн дэлхийн зах зээлийн үнэ ханш ч өссөөр байгаа нь Монголын эдийн засаг, санхүүгийн өсөлт хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байна. Хэрэв Хятадын эдийн засгийн тогтвортой хөгжил, зах зээлийн эрэлт хэрэгцээний тасралтгүй өсөлт байгаагүй бол Монголын эдийн засгийн хөгжил, экспортын бараа бүтээгдэхүүний үнэ ийм өндөр хурдацтай нэмэгдэхгүй, тэр хэмжээгээр санхүүгийн орлого ч нэмэгдэхгүй байсан болов уу.

Хөрөнгө оруулалтын хувьд авч үзвэл Хятад улсын зүгээс оруулж буй хөрөнгийн хэмжээ жилээс жилд эрс нэмэгдэх хандлагатай байна. Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн мэдээлснээр 2006 оны эцсийн байдлаар Монгол Улсад 93 орны 6200 орчим компани 1.8 тэрбум ам долларын хөрөнгө оруулсаны дотор БНХАУ оруулсан хөрөнгийн хэмжээ /841.5 сая ам долл. буюу 46.6% / болон компаний тоогоор /44.3% / тэргүүлсэн байна.

Сүүлийн жилүүдэд БНХАУ-аас хамгийн ихээр хөрөнгө оруулж буй салбар бол уул уурхай, газрын тосны геологи хайгуул, олборлолт юм. БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Петрочайна Дачин Тамсаг /Монгол/” ХХК нь Дорнод аймгийн нутаг

<sup>12</sup> МОНЦАМЭ-гийн мэдээ, 19.12.2007

<sup>13</sup> Монгол Улсын статистикийн эмхтгэл-2006, Улаанбаатар, 2007 хуудас-240

<sup>14</sup> Монгол Улсын статистикийн эмхтгэл-2006, Улаанбаатар, 2007 хуудас -241

дахь Тамсагийн сав газрын Тосон-Уул-ХИХ, Буйр-ХХИ, Тамсаг-ХХИ талбайнуудад Монгол Улсын засгийн газартай АНУ-ын Соко Интернэшнл байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний /БХГ/ эрх, үүргийг 2005 оны 8 сард шилжүүлэн авснаас хойш жил бүр хайгуулын үйл ажиллагаагаа эрчимжүүлж байгаа юм. Тус компани нь Тамсагийн сав газар дахь газрын тосны хайгуулын ажилдаа 2007 онд 202 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийж, 3300 км<sup>2</sup> талбайд 3 хэмжээст, 307 тууш км-г 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийжээ. 2008 онд хөрөнгө оруулалтаа 2007 оныхоос 1,5 дахин нэмэгдүүлж 350 сая ам.долларт хүргэх бөгөөд улмаар гүйцэтгэх ажлын хэмжээг 1.7 дахин нэмэгдүүлж олборлолтыг нэг сая баррельд хүргэхээр төлөвлөсөн байна. Тус компани нь 2008 оны хоёрдугаар улиралд үйлдвэрлэлийн олборлолтыг эхлэхээр төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр Монгол орон албан ёсоор газрын тос олборлогч орон болсноо зарлаж, манай орны газрын тосны салбарын түүхэнд онцгой үйл явдал болох юм.<sup>15</sup>

Хөдөлмөрийн зах зээл буюу Монголын бүтээн байгуулалтын ажилд хятадын ажиллах хүч улам бүр чухал үүрэг гүйцэтгэх болжээ. 2007 оны 12-р сард Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн хэрэгжилтийн байдалтай танилцсан УИХ-ын ажлын хэсэг Аюулгүй байдал, гадаад бодлогын болоод Нийгмийн бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанд хийсэн ажлаа танилцуулжээ. Уг хурал дээр Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас хийсэн судалгаагаар 2007 оны эхний 9 сарын байдлаар манай улсад гадаадын 76 орны 14767 иргэн хөдөлмөр эрхэлж байгаагаас 10367 нь БНХАУ-ын иргэн байгаа тухай мэдээлсэн ажээ.<sup>16</sup>

Дээр дурдсан тоо баримт, мэдээлэл бол хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааны өнөөгийн түвшинд тулгуурлан гаргасан зүйл бөгөөд хэрэв Монгол Улсын уул уурхай, газрын тосны олборлох салбар хөгжлийн эхэн шатандаа байгаа гэж үзвэл Хятадын эдийн засаг, түүний дотор ашигт малтмал, цахилгаан эрчим хүч, газрын тосны

асар том зах зээл нь Монголын эдийн засгийн хөгжилд үзүүлэх эерэг, таатай нөлөө эрс нэмэгдэх төлөв ажиглагдаж байна.

Гэхдээ аливаа зүйл ямагт хоёр талтай байдгийн адил Хятадын эдийн засгийн хөгжил дээрх давуу тал, нааштай нөлөөг үзүүлэхийн зэрэгцээ Монголын эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө, сорилт, өрсөлдөөнийг ч бий болгож байна. Хятадын эдийн засгийн үсрэнгүй хөгжил Монголд үзүүлэх сөрөг талуудын дотроос олон нийтийн дунд хамгийн их тархсан үзэл ойлголт бол Монгол улс Хятадын зах зээлийн түүхий эдийн хавсарга болох, түүний хараат байдалд орох аюул юм. Монголын нүүрс, газрын тос, цайр, алт, зэс, газрын ховор элемент, хайлуур жонш, төмрийн хүдэр гэх мэт эрдэс баялгийг хятадууд хамгийн хямд өртөг зардлаар хаман авах, стратегийн чухал салбаруудад хяналт байр сууриа нэмэгдүүлэх гэсэн бодлого, үйл ажиллагаа сүүлийн үед эрс нэмэгдлээ. Түүнээс гадна гол төлөв Хятад улсын иргэд, жижиг компаниуд Монгол улсын хууль дүрмийг зөрчих, ялангуяа байгаль орчныг бохирдуулах, татвараас нуугдах, хил гаалиар хориотой бараа бүтээгдэхүүн оруулж гаргах, виз хэтрүүлэн удаан хугацаанд оршин сууж нууцаар хөдөлмөр эрхлэх гэх мэт хууль бус үйлдлүүд олонтаа гарах болсон нь энэхүү айдас болгоомжлолыг улам бүр нэмэгдүүллээ.

Сүүлийн жилүүдэд Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа, ялангуяа Монголд хөрөнгө оруулж буй Хятадын компаниудад тулгарч буй хамгийн бэрхшээлтэй асуудлын нэг бол хэлний асуудал болоод байна. Нэг талаас нутгийн монгол хүмүүсийг ажилд авах, сургалт явуулах, нөгөө талаас Монголын татвар, хяналтын байгууллагууд хятадын компаниудын үйл ажиллагааг хянаж шалгахад, бизнесийн ил тод байдлыг хангах, үйл ажиллагаагаа Монголын олон нийтэд таниулан сурталчлахад хэлний бэрхшээл ихээхэн саад учруулж байна. Дорнодын Тамсагт газрын тосны хайгуул хийж байгаа “Петрочайна Дачин Тамсаг” ХХК дээрх шалтгааны улмаас 3000-4000 хятад ажилчид Монголд оруулж ирэн ажиллуулах

<sup>15</sup> 2008 оны газрын тосны хайгуул, олборлолтын хөтөлбөр, төсвийг хэлэлцэн баталжээ. “Зууны мэдээ” сонин. 2007.12. 20

<sup>16</sup> Манай улсад 76 орны 14767 иргэн ажилладаг. “Зууны мэдээ” сонин. 2007.12. 20

сонирхолтой байдаг нь манай улсын хууль тогтоомжтой зарим талаар зөрчилдөх, нутгийн иргэдийн зүгээс эсэргүүцэл дургүйцэл үүсгэх гэх мэт асуудал бэрхшээл төрүүлж байна. Цаашид Хятадын тал дулааны том цахилгаан станц барих, уул уурхайн томоохон төслүүд хэрэгжүүлж эхлэх үед Хятадын компаниудын үйл ажиллагааг ил тод байлгах, хятад ажилчдын тоог бууруулах нийгмийн шахалт шаардлага өсөн нэмэгдэхийн хэрээр эл асуудал нэлээд хүндрэх төлөвтэй байна.

### **Хятадын софт хүчин чадлын нөлөө Монголд нэмэгдэж байна**

Хятадын эрх баригчид сүүлийн жилүүдэд зөөлөн хүч чадлын үүрэг ач холбогдлыг нэн чухалчлан, маш идэвхитэй бодлого явуулж байна. Хятад барааны чанарын асуудалтай уялдан нэр хүнд нь унаж, Хятадын байгаль орчны бохирдол үндэстний хүрээ хязгаараас хальж, цэрэг, санхүүгийн хүч чадал нь өдөр хоногоор зузаарч, “Хятадын аюул занал” үзэл ойлголт түгэн дэлгэрэхийн эсрэг Бээжин юуны өмнө хөрш болон хөгжиж буй орнуудын дунд БНХАУ-ыг худалдааны том түнш орон, хөрөнгө оруулагч, хандивлагч хэмээн үзүүлэх, бодит байдал дээр нотлох явдал софт хүч чадлын нэг чухал зорилт юм.

Мөн түүнчлэн Хятад улс бол энхийг эрхэмлэсэн, хөгжил дэвшилд тэмүүлсэн, хүн төрөлхтөний соёл иргэншлийн том өлгий, хөгжиж буй орнуудын үлгэр дууриал, бас өмөг түшиг, олон улсын аливаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадахуйц, дэлхийн хүчирхэг гүрэн гэдгийг таниулан сурталчлах хүчтэй бодлого явуулахыг эрмэлзэж байна.

Жон Хопкинсийн сургуулийн Хятад судлалын салбарын захирал, профессор Дэвид М. Лэмптон саяхан бичсэн “Хятадын хүч чадлын гурван төрх: хүч, мөнгө, оюун санаа” хэмээх номондоо<sup>17</sup>, хүч чадлыг тулган хүлээлгэх, шагнан урамшуулах, татан дагуулах гэсэн гурван хэлбэрээр илэрийлж болох бөгөөд товчхоноор буу

зэвсэг, мөнгө хөрөнгө, үзэл санаа юм. Хятадын эрх баригчид энэ 3 чиглэлийг ижил түвшинд хөгжүүлэх, цэрэг, эдийн засаг, оюун санааны хүч чадлаа нэгэн зэрэг зузаатгах бодлого явуулж байна. Маогийн хүчинд дулдуйдах бодлого, Дэнгийн эдийн засгийн чадавхиа өсгөх шинэтгэлийн бодлогын дараа, Ху Жинтао оюуны хүчийг хослуулсан цогц чадавхиа өсгөхийг чармайж байна. Өнөөгийн эрх баригчдын дэвшүүлж буй зүй зохистой, өв тэгш нийгэм байгуулах зорилт, шинжлэх ухаанд тулгуурласан хөгжлийн онол зэргийг энэ чиглэлд хамааруулж болох юм.

Лэмптоны дэвшүүлж буй бас нэг чухал санаа бол АНУ Хятадын хүчин зүйлийг хэтрүүлэх эсвэл дутуу үнэлэх нь адилхан маш ноцтой уршиг дагавартай. Хятад маш том, маш чухал, маш эрчимтэй, маш олон орон хамтран ажиллахыг сонирхож буй тул хүчээр шахах эсвэл үл тоомсорлох бус, зөвхөн харилцах, зохицох/engagement/-оос өөр сонголт байхгүй гэдгийг цохон тэмдэглэсэн явдал юм.

Ийм байдал Хятадын хөрш зэргэлдээ бүх орнууд, түүний дотор Монгол шиг жижиг оронд хувьд бүр ч илүүтэй илэрч байна. Хятадын эрх баригчдын хөрш орнууд, бүс нутгийн хэмжээнд явуулж буй бодлого, мөн түүнчлэн Монгол-Хятадын харилцаанд гарч буй зарим тулгамдсан, зөрчилтэй асуудлын мөн чанар, учир шалтгааныг ухан ойлгох үүднээс Бээжингийн зүгээс эрх ашиг, нөлөөний хүрээгээ бэхжүүлэх талаар хоёр талын болон хүрээлэн буй бүс нутгийн хүрээнд явуулж буй зөөлөн хүч чадалтай холбогдсон бодлого, үйл ажиллагааны зарим чиглэлээс дурдахад<sup>18</sup>,

-Хятад улсын нэр хүнд, нөлөө, ялангуяа хөрш болон хөгжиж буй орнуудад софт хүчин чадлын нөлөөгөөр өсч байна. 1990 оны сүүлч үеэс эхлэн Хятадын хэл, соёл, дипломат бодлого, бизнес, хил худалдаа, урлаг, эмнэлэг, хоол хүнс, спорт гэх мэт олон чиглэлээр гадаадынхны анхаарал сонирхлыг татаж байна.

<sup>17</sup> The Faces of Chinese Power, David M.Lampton, FOREIGN AFFAIRS, January/February 2007, pp -115-127

<sup>18</sup> Chinese Soft Power in Southeast Asia (Part I,II) By Josh Kurlantzick | Monday, July 02, 2007, “The Globalist”, Charm Offensive: How China’s Soft Power Is Transforming the World by Josh Kurlantzick. Copyright 2007, Yale University Press.

-Цэргийн хүч чадлын сөрөг нөлөө бөгөөд хязгаарлагдмал байдлыг харгалзан, хөрш орнуудын маргаантай аливаа асуудлыг/ Тайваниас бусад/ цэрэг зэвсгийн хүчээр далайлган шийдвэрлэх хандлагаас аль болох зайлсхийх, хөгжиж буй болон буурай орнуудын эрх ашгийг хамгаалагчийн дүр төрхийг олж авахыг эрмэлзэх болов.

- Хөгжиж буй орнуудын эрх ашгийг хамгаалаад зогсохгүй үлгэр дууриал болон тэдгээр орны эрх баригчид, ард олныг хөгжил цэцэглэл, хүч чадлаараа татан дагуулахыг эрмэлзэж байна. Вьетнам, Лаос, Камбож хятадын туршлагыг нэн идэвхийлэн ашиглаж байгаа, магадгүй Хойд Солонгос, Мьянмар ч хятад загварыг сонирхон судалж байж болох юм. ОХУ, Латин Америкийн орнууд ч Хятадын зарим туршлагыг хэрэглэж эхэлсэн тухай мэдээ Синьхуагийн мэдээнд үзэгдэх боллоо.

-Хятадын хөгжил түргэсэн дэлхий дахины бизнесийн үйл ажиллагаа тус орон руу чиглэх болсонтой уялдан хятад хэл, соёлын нөлөө ч өсөн нэмэгдэж байна. Хятадын засгийн газар үүнийг бүхий л талаар дэмжих бодлого явуулж байна. Хятад хэлний гүүр олон улсын уралдаан, Күнзийн сургуулиуд, Хятадын их дээд сургуулиудад улсын тэтгэлгээр олон мянган гадаад оюутан, докторант, дадлагажуулагчдыг сургах явдлыг жил бүр өргөжүүлж байна.

-Эдийн засгийн ялангуяа буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт зэргийг софт хүчин чадлын эдийн засгийн хүчтэй, нарийн арга хэрэгсэл болгож байна. Хятадын зээл, тусламж Африкийн ядуу буурай орнууд төдийгүй Зүүн Өмнөд Азийн орнуудад нэмэгдэж байна. Жишээ нь ЗӨА орнуудад үзүүлсэн Хятадын тусламж АНУ-ынхаас даруй 2-3 дахин илүү байв. Зээл тусламж олгохдоо хөгжингүй орнууд шиг янз бүрийн болзол нөхцөл тавихгүй ердөө Нэг

Хятадын бодлогыг хүлээн зөвшөөрсөн байх л шаардлага тавьдаг ажээ. Чөлөөт худалдааны хэлэлцээр, худалдааны тааламжтай нөхцөл олгох бодлогыг ч ялгавартай явуулж байна.

-Хятадын эдийн засаг, соёлын нөлөөг дамжуулах бас нэг том суваг бол хятад иргэдийн шилжилт хөдөлгөөн, цагаачлал юм. Сүүлийн 10 жилд Хятадын засгийн газар улс дотроо төдийгүй хилийн чанад руу хятад иргэдийн шилжин суурьших үйл явцад саад учруулах, хяналт тавих явдлаа нэлээд сулруулсан. Хятадууд аялал, жуулчлал, боловсрол, бизнесийн шугамаар гадаад орнууд руу аялахад бараг хориг саадгүй болсон. Энэхүү бодлогын үр нөлөө хил залгаа бүх орнуудад илэрсэн бөгөөд ялангуяа хүн ам цөөн, нягтшил багатай Монгол, ОХУ-ын Сибирь Алс Дорнодын орнуудад маш ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй байна. Урьд өмнө ажил амьдрал хайж цагаачилж байсан хятадуудын араас мөнгөө өсгөх гэсэн жижиг бизнесменүүдийн том урсгал хөрш орнуудыг нөмөрч байна. Тэд ашиг орлогын хойноос хөөцөлдөх, хөрөнгө мөнгөө арвижуулахын тулд авилга, танил тал татах, хүрээлэн буй орчныг бохирдуулах гэх мэт бүхий л арга сиймхийг ашиглах гэсэн мугуйд хүсэл эрмэлзэл нь хоёр орны харилцаанд, Монгол дахь Хятад улсын нэр хүндэд багагүй бэрхшээл, хохирол учруулж байна.

Эцэст нь дүгнэн хэлэхэд Монгол-Хятадын харилцаа хөгжлийн шинэ үе шатандаа дэвшин орж буй өнөө үед Монгол Улсын хөгжил дэвшилд нөлөөлөх өмнөд хөршийн хөгжлийн хүчин зүйлсийн эерэг сөрөг талуудыг сайтар судлан таньж мэдэхийн зэрэгцээ хоёр орны харилцааг харилцан ашигтай, тогтвортой хөгжүүлэх, хоёр орны ард түмний итгэлцэл, эв найрамдлыг бэхжүүлэх талаар хоёр тал янз бүрийн түвшинд олон талын арга хэмжээ авах, ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.